Уламжлалт анагаах ухааны хүний бие махбодын өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг харьцуулсан судалгааны үр дүн

Э.Энхмягмар[1], Б.Дагвацэрэн[2], Б.Цэрэнцоо[3]

[1]АШУҮИС МАУОУС
[2]УАУТХ
[3]АШУҮИС. МАУОУС

Түлхүүр үг:
Хий, шар, бадган
Бие махбодын өвөрчлөл
Модификаци

ӨГҮҮЛЭЛ

Товч утга: Үндэслэл: Хүн төрсөн цагаасаа эхлэн бие, хэл, сэтгэлийн онцлогоор ялгаатай байдгийг өрнө дорнийн анагаах ухаанд хүлээн зөвшөөрч ирсэн билээ. Хүний биеийн галбир төрх, физиологийн үйл ажиллагаа, зан чанарыг өвчинд өртөх байдалтай нь уялдуулан янз бүрийн өвөрчлөлийн хэлбэр болгон ангилах оролдлогууд хийгдсээр иржээ. Уламжлалт анагаах ухаанд сурвалж, тайлбар зохиолуудад хүний өвөрмөц чанарын тухай эртнээс ангилж авч үзэж ирсэн. Хүний бие бялдарын өвөрчлөл гэдэг нь бие махбодод байх хий, шар, бадганы их, багаас шалтгаалсан төрөлх тогтсон биеийн мөн чанар юм. Өвөрчлөлийг хийн өвөрчлөл, шарын өвөрчлөл, бадганы өвөрчлөл гэсэн дан 3; “хий-шар”, “шар-бадган”, “хий-бадган” хавсарсан өвөрчлөл гэсэн 3; хий, шар, бадган гурвуулаа хурсан өвөрчлөл 1; бүгд 7 зүйл хэмээн авч үздэг.[4] Тухайн өвөрчлөлд хамрагдаж буй хувь хүнийг өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчилэхэд нь тохирсон идээ ундаа, явдал мөр, эм, заслын үйлийг цаг улиралд шүтэн зохицолдуулж бие, хэл, сэтгэлийг эрүүл байлгах, урт наслуулах боломж байгаа тул хувь хүний өвөрчлөл судлаачдын анхаарлыг ихэд татах болсон. Өвчнөөс урьдчилан сэргийлхийн тулд тухайн хувь хүний бие махбодын өвөрчлөлийг цогцоор судалж үзэх шаардлагатай байна. Иймд энэ талаар гарсан судалгаа шинжилгээний ажил дутмаг байгаа учир уг асуудлын орчин цагийн анагаах ухаанд гүйцэтгэх үр нөлөө зэргийг харгалзан үзээд энэхүү сэдвийг сонгож авлаа. **Зорилго:** Уламжлалт ангаах ухааны бие махбодын өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг харьцуулан модификац хийж зарим судалгааны аргаар нотолгоожуулах. **Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:** Судалгаанд харьцангуй эрүүл хүмүүсээс эпидемиологийн аналитик судалгааны “агшингийн” (cross - sectional study) загварыг ашиглан явуулсан. Уламжлалт анагаах ухааны хүний бие махбодын өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг харьцуулан модификац хийж судалгааны аргаар нотолгоожуулах судалгааг Монгол улсын АШУҮИС-н оюутнуудаас 2019 оны 03 сараас эхлэн нас, хүйс харгалзахгүйгээр түүвэрлэн судалгаанд хамруулав. **Үр дүн:** Бидний судалгаанд нийт 90 оролцогч хамрагдсан бөгөөд хүмүүсийн дундаж наслалт (стандарт хазайлт) 25.0(6.3) ба 84.4%(n=76) эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн дундаж даралт СД 110.278 мм.муб, ДД 73.556 мм.муб байв. **Дүгнэлт:** 1. Хамгийн түгээмэл тархсан хоёр хэлбэр Хятад болон Энэтхэгийн /аюурвед/ уламжлалт анагаах ухааны онолоор хүний бие махбодын өвөрчлөлийг тайлбарласан байна. 2. Судалгаанд хамрагдсадын хавсарсан өвөрчлөлтэй нь дийлэнх хувийг, хурмал өвөрчлөлтэй хамгийн бага хувийг тус тус эзэлж байна.

Үндэслэл: Хүн төрсөн цагаасаа эхлэн өөрийн бие, хэл, сэтгэлийн онцлог чанараар ялгаатай байдгийг өрнө дорнийн анагаах ухаанд хүлээн зөвшөөрч ирсэн байна.[1] Хүний биеийн галбир төрх, физиологийн үйл ажиллагаа, зан байдлыг ямар нэгэн өвчинд өртөх байдалтай нь уялдуулан янз бүрийн өвөрчлөлийн хэлбэр болгон ангилах оролдлогууд хийгдсээр ирсэн.[2] Эртний сэтгэгч өрнийн анагаах ухааны үндсийг тавигч Гипократ (МЭӨ 460-377) нь тухайн үеийн философи үзлийн үндэс суурин дээр хүний бие бялдарыг дөрвөн төрлөөр ялган тэмдэглэсэн байдаг.[7] Эдгээр шим шүүс нь жигд хувиарлагдаж байвал хэвийн, буруу холигдвол өвчин болно гэж түүний дэвшүүлсэн энэхүү үзлийг шингэний эмгэг судлал хэмээн нэрлэж одоог хүртэл

баримталсаар байгаа билээ.[8-10] Уламжлалт анагаах ухааны сурвалж болон тайлбар зохиолуудад хүний төрөлх өвөрмөц чанарын тухай асуудлыг эртнээс ангилж авч үзэж ирсэн.[2] Хувь хүний бие махбодын өвөрчлөл, сэтгэхүйн урвалж чанарын онцлогууд нь өөр хоорондоо салшгүй холбоотой ба эдгээрийг цогцоор нь судлах асуудал анхаарал татаж байгаа ба хүнийг өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, өвчнийг бус өвчтнийг эмчлэх зарчмийг баримтлах бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд тухайн хувь хүний бие махбодын өвөрчлөлийг харгалзан үзэх шаардлагатай байдаг гэжээ.[12]

Уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онол ёсоор хүний бие бялдарын өвөрчлөл гэдэг нь бие махбодод байх хий, шар, бадганы их, багын хувиас шалтгаалсан төрөлх тогтсон биеийн мөн чанар юм. Өөрөөр хэлбэл эхийн умайд хөврөл тогтох үеийн эцэг, эхийн дусал, цус хоёрт эзлэх хий, шар, бадганы хувь хэмжээ ямар байсан, умайд хөврөл бойжих явцад эхийн идээ унд, явдал мөрөөс болж хий, шар, бадганы арвидсан, хорогдсон хэмжээ зэргээс шалтгаалан хий, шар, бадган нь янз бүрийн харьцаатайгаар тогтсон байдаг.[5,6] УАУ-д хүний бие бялдрын өвөрчлөлийг хийн өвөрчлөл, шарын өвөрчлөл, бадганы өвөрчлөл гэсэн дан 3; “хий-шар” хавсарсан өвөрчлөл, “шар-бадган” хавсарсан өвөрчлөл, “хий-бадган” хавсарсан өвөрчлөл гэсэн хавсарсан 3; хий, шар, бадган гурвуулаа хурсан өвөрчлөл 1; бүгд 7 зүйл хэмээн авч үздэг.[2-4]

Мөн тухайн өвөрчлөлд хамрагдаж буй хувь хүний өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчилэхэд ямар төрлийн өөрт нь тохирсон идээ ундаа, явдал мөр, эм, заслын үйлийг цаг улирлын хувиралд шүтэн зохицолдуулж чадваас бие, хэл, сэтгэл эрүүл оршиж урт наслах боломжтой байдаг. Иймээс хүн эрүүл байх нь юуны түрүүнд сэтгэл зүй, бие махбод, нийгмийн идэвх, ажиллах чадвараар нь илэрхийлэгддэг бөгөөд эрдэмтэн Ю.П.Лисицыний тодорхойлсноор хүн эрүүл саруул байж, урт удаан наслахад эрүүл мэндэд нөлөөлдөг бүх хүчин зүйлээс экологийн нөлөө 20-25%, биологийн буюу удамшлын хүчин зүйл 20%, эмч, эмнэлгийнхний үүрэг 10%-иас хэтэрдэггүй. Харин үлдсэн 50% нь эрүүл мэнддээ сул анхаарсан байдал эзэлдэг ажээ.[6] Орчин үеийн анагаах ухаанд хувь хүний өвөрчлөлийн онцлогтой холбоотой үүсдэг зарим өвчнүүд судлаачдын анхаарлыг ихэд татах болсон.

Эрхтэн тогтолцоо болон сэтгэхүйн мөн чанараас хамааран бие бялдрын өвөрчлөлийг олон талаас нь ангилж үздэг. Бие бялдрын онцлогийг тусгасан ангилал өнөөдрийг хүртэл эрдэмтдийн дунд нэгдсэн санал байдаггүй. Иймд энэ талаар гарсан судалгаа шинжилгээний ажил ховор байгаа болон уг асуудлын орчин цагийн анагаах ухаанд гүйцэтгэх үр нөлөө зэргийг харгалзан үзээд энэхүү сэдвийг сонгож авлаа.

Зорилго: Уламжлалт ангаах ухааны бие махбодын өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг харьцуулан модификац хийж зарим судалгааны аргаар нотолгоожуулах.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгаанд харьцангуй эрүүл (харьцангуй эрүүл хүн гэж бие махбод дотоодод нь эмгэг өөрчлөлт орж байгаа боловч тэр нь уг хүний хөдөлмөрийн чадвар, амьдралын идэвхтэй байдлыг алдагдуулахгүй байхыг ойлгодог) хүмүүсээс эпидемиологийн аналитик судалгааны “агшингийн” (cross - sectional study) загварыг ашиглан явуулсан. Судалгааны үр дүнг SPSS 20.0 программаар боловсруулаа. Уламжлалт анагаах ухааны хүний бие махбодын өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг харьцуулан модификац хийж судалгааны аргаар нотолгоожуулах судалгааг Монгол улсын АШУҮИС МАУОУС-н оюутнуудаас 2019 оны 03 сараас эхлэн нас, хүйс харгалзахгүйгээр түүвэрлэн судалгаанд хамруулсан ба уламжлалт анагаах ухааны эх бичиг, сурвалж тайлбар зохиолуудад хүний бие махбодын өвөрчлөл тухай асуудлыг харьцуулан судлав.

Үр дүн:


Сурвалж зохиолуудаас өвөрчлөлийг өрнө, дорнын тодорхойлох аргачлалын харьцуулалт хийсэн үр дүн: Анагаах ухаан тус бүр нь олон мянган жилийн турш хөгжсөн системтэй, өвөрмөц онол, практик тогтолцоог бүрдүүлжээ. Азийн уламжлалт анагаах ухааны хамгийн түгээмэл тархсан хоёр хэлбэр бол Хятадын уламжлалт анагаах ухаан, Энэтхэгийн /аюурвед/ уламжлалт анагаах ухаан юм. Аюурведын анагаах ухаан нь баруун азийн орнуудад /энэтхэг, пакистан, төвд/ зонхилдог бол харин хятадийн анагаах ухааны ин-янгийн сургаал зүүн азийн орнуудад /хятад, солонгос, япон, вьетнам/ зонхилдог байна.[7] Аюурведын анагаах ухаан Vatta, pitta, kapha буюу гурван dosha гэх бөгөөд 5 элемент буюу одон зурхайн 5 махбодоос /шороо, ус, гал, хий, огторгуй/ үүсэлтэй гэж үзэн бие махбодын өвөрчлөлийг тайлбарладаг байна. Аюурведын анагаах ухаан нь өвөрчлөлийг 7 төрөлд авч үзэж байгаа нь монголын уламжлалт анагаах ухааны хүний бие махбодын өвөрчлөлтэй ижил харагдаж байна. Сасангийн анагаах ухаан нь Хятадын АУ-ны филисофийн үндэс болох Инь-Янгийн онолд тулгуурлан үүссэн бөгөөд Инь-Янгийн онолоос дэлгэрүүлж физиологи, патологийн ухагдахуунд суурилан Инь-2 Янг-2 буюу уушги, элэг, дэлүү, бөөрний өвөрчлөлийг гаргасан байна. Харин үндэслэгч Хятадын анагаах ухаан нь Инь-Янгийн онолыг арга билэг буюу таван махбодын /мод, гал, шороо, төмөр, ус/ үүднээс тайлбарлан бие махбодын өвөрчлөлийг тодорхойлдог байна.

ӨГҮҮЛЭЛ

Биеийн жингийн индекс болон өвөрчлөлийг харьцуулсан үр дүн:

	Хий шар	Шар хий	Шар бадган	Хий бадган	Бадган хий	Бадган шар	Хурмал	Нийт
Жингийн дутагдалтай	7	8	1	0	0	0	0	16
18.5-аас бага	43.80%	50.00%	6.30%	0.00%	0.00%	0.00%	0.00%	100.00%
Хэвийн	18	32	9	0	0	2	1	62
18.5-24.9	29.00%	51.60%	14.50%	0.00%	0.00%	3.20%	1.60%	100.00%
Жингийн илүүдэлтэй	1	4	2	2	0	0	0	9
25.0-29.9	11.10%	44.40%	22.20%	22.20%	0.00%	0.00%	0.00%	100.00%
Таргалалттай /1-р зэрэг/	0	0	2	0	1	0	0	3
30.0-34.9	0.00%	0.00%	66.70%	0.00%	33.30%	0.00%	0.00%	100.00%
Нийт	26	44	14	2	1	2	1	90
	28.90%	48.90%	15.60%	2.20%	1.10%	2.20%	1.10%	100.00%

Нийт судалгаанд 90 хамрагдсан хүнээс шар-хий хавсарсан өвөрчлөлтэй 44; хий-шар хавсарсан өвөрчлөлтэй 26; шар-бадган хавсарсан өвөрчлөлтэй 14; хий-бадган хавсарсан, бадган-шар хавсарсан тус бүр 2; бадган-хий хавсарсан, хурмал өвөрчлөлтэй тус бүр 1 байсан.



Зураг 1. Бие махбодын өвөрчлөл

Үүнээс биеийн жингийн индексийг тодорхойлж харьцуулахад жингийн алдагдалтай буюу 18,5-с бага нийт 16; хэвийн жинтэй 62; жингийн илүүдэлтэй 9; нэгдүгээр зэргийн таргалалттай нийт 3 хүн байсан. Жингийн алдагдалтай 16 хүмүүс хий-шар хавсарсан, шар-хий хавсарсан өвөрчлөлтэй байсан ба жингийн илүүдэлтэй таргалалттай хүмүүс шар-бадган хавсарсан, бадган-хий хавсарсан өвөрчлөлтэй байлаа. Хэвийн жинтэй 62 хүний шар-хий хавсарсан өвөрчлөлтэй 51,6%(n=32); хий-шар хавсарсан өвөрчлөлтэй 29,0%(n=18); шар-бадган хавсарсан өвөрчлөлтэй 14,5%(n=9); бадган-шар хавсарсан өвөрчлөлтэй 3,2%(n=2); хурмал өвөрчлөлтэй 1,6%(n=1) байлаа. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дундаж наслалт (стандарт хазайлт) 25.0(6.3) ба 84.4%(n=76) эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн дундаж даралт СД 110.278 мм.муб, ДД 73.556 мм.муб байв.

Хэлцэмж: Өрнө дорнийн анагаах ухаан нь хоёр өөр онол эмчилгээний аргатай боловч хоёулаа хүнийг эмчилж эрүүл байлгах нэг зорилготой ба хүн төрсөн цагаас эхлэн бие бялдар, оюун ухаан, зан араншингаараа өөр ялгаатай гэдгийг эрт дээр үеэс хүлээн зөвшөөрч ирсэн бөгөөд энэ талаар онол сургаал, судалгаа шинжилгээ цөөнгүй хийгдэж иржээ. Мөн Дорно дахины эртний Энэтхэгт үүсч бий болсон Аюурведийн анагаах ухаан нь НТӨ 6000 жилийн өмнөөс үүсэлтэй бөгөөд хүний бие махбодын өвөрчлөлийг Vata, Pitta, Kapha гэсэн 3 do-sha дан дангаар 3, хавсарсан 3, гурвуул хурсан нэг нийт 7 өвөрчлөлд хувааж үздэг. Энэ хамгийн анхны цэгцтэй онол бөгөөд өнөө бидний үед уламжлагдан баяжиж ирсэн байна. Энэ сургаал нь манай уламжлалт анагаах ухааны онолтой ижил байна. Түүнчлэн эртний Хятадын анагаах ухаанд, Инь-Янгийн онолд тулгуурласан таван махбодын сургаал нь орчлон, ертөнцийн гарал үүслийг шороо, ус, гал, хий гэх анхдагч элементүүдийн үүсэл хөгжлийн үр дүнд бий болсон гэж нотолсон онол юм.

Хий, шар, бадганыг одон зурхайд 5 махбодод төлөөлүүлэн авч үздэг. Шороо+усан махбодуудыг нийлүүлэн бадган, гал махбодыг шараар, хий махбодыг хийгээр төлөөлүүлэх ба огторгуй махбодын мөн чанарыг нийтэд нь түгэн оршиж байгаа гэж үздэг. Хүн эхээс төрөхдөө таван махбодын аль нэг нь давамгайлсан байх ба зөвхөн тэр махбодод заясан өөрийн өвөрмөц өвөрчлөлтэй төрдөг хэмээн бичсэн байдаг бол ертөнц дээр адилхан хүн байдаггүй бөгөөд тэдгээрийн зан араншин, үзэл бодол, таашаал, цул, сав эрхтний бүтэц, өвчлөх байдал, хоол унд, эмийн бодисын үйлдлийг мэдрэх чадвар, эрс өөр байдаг гэж үздэг бөгөөд энэ дагуу "нэг хүн-нэг эмчилгээ" гэсэн зарчмыг Инь-Янгийн онолтой шүтэлцүүлэн гаргасан байдаг байна.

Эдгээр уламжлалт тайлбар зохиолуудын мөн чанар харилцан үл зохилдовч тэдгээр нь биеийн шар үсны нүхэнд хүртэл хамт оршиж үйл үйлдэх бөгөөд эдгээрийн үйл үгүй бол бие үгүй хэмээн тодорхойлдог. Хий, шар, бадган харилцан бие биедээ түшиглэн биеийн бүхий л хэсэгт энэ тэнцүү оршиж эрдэм чадал, үйлдлээ үзүүлдэг байна гэсэнтэй дүйж байна. Бидний судалгаанд хамрагдсан хүмүүсээс шар-хий хавсарсан өвөрчлөлтэй 44; хий-шар хавсарсан өвөрчлөлтэй 26; шар-бадган хавсарсан өвөрчлөлтэй 14; хий-шар хавсарсан, бадган-шар хавсарсан тус бүр 2; бадган-шар хавсарсан, хурмал өвөрчлөлтэй тус бүр 1 тохиолдол гарсан. Эдгээр үр дүн нь Б.Цэрэнцоо (2010) нарын АНУ-ын Robert Sachs (1995)-ийн боловсруулсан хувь хүний биеийн өвөрчлөлийг тогтоох тестийн дагуу 18-79 насны 500 хүнд явуулсан судалгаагаар хий-шар хавсарсан 63.2%, шар-бадган хавсарсан 18.4%, хий-бадган хавсарсан 18,4% үр дүн гарсантай дүйж байна.

Мөн Г.Өлзийбаатар (2011) нарын Д.Дагвацэрэн, Ө.Батчимэг, Г.Наранцэцэг (2003) нарын аргаар боловсруулсан судалгаанд хий өвөрмөц чанартан 8.05%, шар өвөрмөц чанартан 15.27%, бадган өвөрмөц чанартан 6.73%, хий-шар хавсарсан өвөрмөц чанартан 41.05%, бадган-хий хавсарсан өвөрмөц чанартан 9.52%, бадган-шар хавсарсан өвөрмөц чанартан 18.88%, хурмал өвөрмөц чанартан 0.49%

тохиолдол гарсан. Тус судалгаанд хий-шар хавсарсан өвөрмөц чанартан 41.05% хамгийн их, хурмал өвөрмөц чанартан 0.49% хамгийн цөөн тохиолдол гарсан гэжээ эдгээр хамгийн их болон цөөн тохиолдсон үр дүн нь бидний судалгааны ажилтай дүйж байна. Энэ судалгааны ажлын хүрээнд уламжлалт анагаах ухааны хүний бие махбодын өвөрчлөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр өрнө дорнын анагаах ухааны үзэл баримтлалд харьцуулан судалж хий, шар, бадганы өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжийг эрүүл мэндийн практикт нэвтрүүлэх ач холбогдолтой болно.

Дүгнэлт:

1. Дорно дахины уламжлалт анагаах ухаанд хамгийн түгээмэл тархсан хоёр хэлбэр Хятад болон Энэтхэгийн /аюурвед/ уламжлалт анагаах ухааны онолоор хүний бие махбодын өвөрчлөлийг тайлбарласан байна.
2. Судалгаанд хамрагдсадын ихэнх хувийг хий-шар хавсарсан, шар-хий хавсарсан өвөрчлөл эзэлж байсан ба харин эсрэгээрээ хий-шар-бадган хувь тэнцүү буюу хурмал өвөрчлөлтэй хүн хамгийн бага хувийг тус тус эзэлж байна.

Ном зүй:

1. *Цэрэнцоо. Б "Уламжлалт анагаах ухааны бие махбодын өвөрчлөлийг анртопометрийн хэмжилт болон сэтгэл судлалын зарим аргаар харьцуулан судлах асуудалд". Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2010 он*
2. *"Анагаах Ухааны Дөрвөн Үндэс" УБ. 1990 он "Биеийн бэлгэ чанарын бүлэг"*
3. *Лувсанчойдог Дарма манрамба (XYII) "Алтан хадмал" ӨМӨЗО. Хөх хот. 1998 он. х.209-233*
4. *"Хөх бидүряа" Өвөр монголын ардын хэвлэлийн хороо 1999 он. х.138-141*
5. *Батчимэг. Ө "Өвчнөөс сэргийлэх, оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик, арга зүйн судалгаа" Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2003 он*
6. *Ганчимэг. Д "Уламжлалт анагаах ухааны биеийн өвөрчлөл, биологийн насны холбоо хамаарлыг тандан судалсан нь" Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2005 он*
7. *Дагвацэрэн. Б, Батчимэг. Ө, Барламова. Т.С, Наранцэцэг. Г "Өвчнөөс сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс" УБ. 2003 он. х. 30-33*
8. *Батсайхан. Б, Дэлгэржав. М "Сэтгэл судлал" УБ. 2013 он х.220*
9. *Бадамханд. Л, Батмөнх. Г, Дашзэвэг. Г, "Хүний Физиологи" УБ. 1989 он х.30-55*
10. *Барзул. Н "Хүний бие галбир, дээд мэдрэлийн үйл ажилгааны хэв шинж, стгэл түгшилтийн хоорондын хамаарал" Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 1998 он*
11. *Сүхбат. Г "Хүний биеийн ерөнхий физиологи" УБ. 2000 он х.155-156*
12. *Баасанжаргал. Б "Стрессийн үеийн мэдрэл шингэний зохицуулалтын хамрал" Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2002 он х.57*
13. *Өлзийбаатар. Г "Монголын уламжлалт анагаах ухааны биеийн өвөрчлөлийн асуудлыг ёзэд мэдрэлийн үйл ажиллагааны хэв шинжүүд тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан судалсан үр дүн" Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2011 он*
14. *Jong Yeol Kim, Duong Duc Pham, and Byung Hee Koh "Comparison of Sasang Constitutional Medicine, Traditional Chinese Medicine and Ayurveda" 2011 https://www.hindawi.com/journals/ecam/2011/239659/*
15. *Robert Sachs "Health for life" 1995. New Mexico. p 25-52*
16. *J. L. Tang, B. Y. Liu, and K. W. Ma, "Traditional Chinese medicine," Lancet, vol. 8-9, pp. 1938–1940, 2008*
17. *B.Patwardhan, D.Warude, P.Pushpangadan, and N. Bhatt, "Ayurveda and traditional Chinese medicine: a comparative overview," Evidence-Based Complementary and Alternative Medicine, vol. 2, no. 4, pp. 465–473, 2005.*

The results of a comparative study of the methods that determining the body's constitution of traditional medicine

E.Enkhmyagmar[1], B.Dagvatseren[2], B.Tserentsoo[3]

[1]ISMS, MNUMS,
[2]TMTI
[3]ISMS, MNUMS

Introduction: It has long been recognized in western and eastern medicine that a human being is distinguished by body, language and emotional features from each other. Attempts to classify various types of body constitutions have been made based on the physical appearance, physiological function, and behavior of the human being and to identify the connections of these characteristics with their susceptibility to diseases. In traditional medicine, the specific characteristics of personal body constitution have long been classified and investigated. The body constitution is a natural mix of the "wind", "bile", and "phlegm" and one's distinguished character is based on the level of the greater or lesser amount of these three. There are three basic types of body constitutions and depending on the single or concomitant of these, there are total of seven types, including three single: "wind", "bile", and "phlegm" and three concomitants: "wind-bile", "bile-phlegm", and "wind- phlegm" and a combination of all three: "wind-bile-phlegm". In recent years, researchers pay particular attention to the personal body constitution theory due to its potential to live longer, healthy and able to prevent diseases if the person can consume food that suitable for one's body and use proper medicine and follow the principles according to the weather condition and season. In order to prevent the disease, it is necessary to study the personal body constitution. Considering the lack of research on this issue and its potential role in modern medicine we aimed to study this topic.

Purpose: The purpose of this study was to compare the body constitution assessment techniques and methodology and to make modifications and validation by some research methods.

Materials and methods: This study is carried out by cross-sectional method and total of 100 relatively healthy people were involved in this study. Study on comparing and modifying the determination methodology of the body's constitution of traditional medicine and its evidence by the research methodology was carried out among students of MNUMS, who were selected randomly regardless of age and gender since March of 2019.

Results: A total of 90 participants were involved in our study. Their average age was 25.0 with a standard deviation of 6.3 and women accounts for 84.4% (n = 76). Also, the mean blood pressure of the study subjects was SD 110,278 mm Hg and DD 73,556 mm Hg.

Conclusion:

1. The two most common forms are Chinese and Indian (Ayurvedic) in traditional medicine, the human body constitution has explained.
2. The majority of patients have mixed type that consisting of two pairs, while the smallest percentage has three-factor convergence body constitution type.

Keywords: wind, bile, phlegm; body constitution; modification